



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/06

Улаанбаатар хот

Гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан  
болон нэгжүүдийн индекс шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай” хууль, Засгийн газрын 2020 оны “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам батлах тухай” 246 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.2.1.3, 2.2.1.4, Засгийн газрын 2021 оны “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх тухай” 2020 оны 226 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.1.12 дугаар заалт, Газрын дүрмийн 7.1.10, Хэлтсийн дүрмийн 2.7.13 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, журмын шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан албан бичигт гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтан Газрын дарга Сүхийн Төмөрдуламын индексийг 01, Орлогч дарга Отгонбаатарын Оджаргалын индексийг 02 байхаар, байгууллагын Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад ашиглах хэлтсүүдийн индексийг шинэчлэн Захиргаа, санхүүгийн хэлтэс 01, Хотын хөгжлийн стандартын хэлтэс 02, Хот нийтийн аж ахуйн стандартын хэлтэс 03, Худалдаа үйлчилгээний стандартын хэлтэс 04, Байгаль орчны стандартын хэлтэс 05, Стандартын хэрэгжилт, хяналтын хэлтэс 06 байхаар тогтоож, мөрдөж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/22 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

3. Тогтоосон индекийг албан бичиг боловсруулах, баримт бичгийн хадгалалт, байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулахдаа мөрдөн ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн Хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ

d:\ajil\2022\14. tushaal blank

1150500027